



## **“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН 2026 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

2026 оны 04 дүгээр сарын 28-ны өдөр “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурал “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн төв байрны 1 давхарт танхим болон цахим хосолсон хэлбэрээр 10 цаг 10 минутаас 11 цаг 50 минутын хооронд 1 цаг 40 минутын турш болж хуралдав.

### **Хурлын дарга:**

Сангийн дэд сайд – Б.Хулан

### **Хурлын тооллогын комисс:**

Коммисын дарга:

“БиДиСек ҮЦК” ХК -ийн Институционал харилцагчийн албаны захирал – Б.Онон

Комиссын гишүүд:

“БиДиСек ҮЦК” ХК -ийн Институционал харилцагчийн албаны ахлах мэргэжилтэн – Э.Пүрэвжаргал

“БиДиСек ҮЦК” ХК -ийн Институционал харилцагчийн албаны мэргэжилтэн – Г.Анхбаяр

### **ХЭЛЭЛЦСЭН НЬ:**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн 2026 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж батлах;

### **СОНССОН НЬ:**

Тооллогын комиссын дарга Б.Онон: “Монголын Хөрөнгийн Бирж” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд саналын эрхтэй нийт 350,463,539 ширхэг хувьцаанаас 68.76% хувь буюу 240,991,242 ширхэг хувьцаа эзэмшиж буй 64 хувьцаа эзэмшигч оролцож, ирц баталгаажсан тул компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг хүчин төгөлдөрт тооцсоныг мэдээлэв.

Хурлын дарга Б.Хулан: “Монголын Хөрөнгийн бирж” хувьцаат компанийн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагааг нээж үг хэлэв.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон Санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах болон Компанийн 2026 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж батлах; гэсэн үндсэн хоёр асуудлыг хэлэлцэн шийдвэрлэж, харин Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг зарлах, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг эцэслэн шийдвэрлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.2.2-д заасны дагуу ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад төрийн төлөөлөл хэрэгжүүлэгчийг нэр дэвшүүлэх боломжоор хангаагүй буюу мөн хуулийн 21.2.1-т заасны дагуу уг асуудлаар хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс санал, удирдамж авах нь зүйтэй тул Төлөөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгож томилох асуудлыг холбогдох хууль

тогтоомжид нийцүүлэн дараагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэхээр хойшлуулав.

Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбат: Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг танилцуулав.

ТУЗ-ийн дарга Д.Тогтохбаяр: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны ажлын тайланг танилцуулав.

Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбат: Компанийн 2026 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг танилцуулав

### **АСУУЛТ, ХАРИУЛТ, САНАЛ:**

Хувьцаа эзэмшигч Даваадорж:

1. 2026 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний тайланд орлого 1% нэмэгдсэн байхад зардал 22%-р нэмэгдсэн байна. Энэ нь бизнес төлөвлөгөөний хувьд хэр зохимжтой вэ?

Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбат: 2026 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд үндсэн үйл ажиллагааны орлого нь үндсэн үйл ажиллагааны зардлаа нөхдөг байх зорилтыг хэвшүүлсэн. Нийт орлогын хувьд 1%-р өсөж байгаа мэт харагдаж байгаа боловч өнгөрсөн жил 10.7 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлсэн, 2026 онд 13.3 тэрбум төгрөг буюу 24%-р өсөх зорилт тавьсан байгаа. Зардлын хувьд бизнес хөгжүүлэлт дээр гол нэмэгдэл үүссэн. Энэ нь шинэ бүтээгдэхүүн гаргах гадагшаа чиглэсэн үйл ажиллагаануудад зарцуулахаар төлөвлөсөн байна. Мөн дараагийн гол нэмэгдсэн зардал нь цалин урамшууллын зардал. Компанийн Үйлдвэрчний эвлэлийн зүгээс ажилчдын цалин зах зээлийн дундажтай харьцуулахад доогуур байгааг илтгэсэн судалгаа шинжилгээг хийж танилцуулсан тул компанийн зүгээс 2026 оны 1 болон 2 дугаар улирлын гүйцэтгэлээс хамаарч үе шаттай нэмэх зардлыг ТУЗ-д танилцуулж батлуулсан болно.

Хувьцаа эзэмшигч Батхишиг.

2. 2026 онд ногдол ашиг тараахдаа 50% тараасан байгаа. 100% тарааж болохгүй юу?

ТУЗ-ийн дарга Д.Тогтохбаяр: Улсын их хурлын тогтоолын дагуу эздийн өмчийн 1% эсвэл цэвэр ашгийн 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийн аль өндөрөөр ногдол ашиг тараах зохицуулалттай байдаг. Хөрөнгийн зах зээл дээр бизнесийн чиглэлд үйл ажиллагаагаа эрхэлж байгаа хувьцаат компанийн хувьд тогтвортой байх зорилтыг тавьж ажилладаг. Хэрэв 100% ногдол ашиг тараах юм бол компанийн үнэлгээ буурч хувьцааны үнэ унах эрсдэл үүснэ.

Хувьцаа эзэмшигч Өлзийбат:

3. Миний хувьд "Монголын хөрөнгийн бирж" ХК-ийн хувьцаа эзэмшигч болон компанийн ажилтны хувьд оролцож байна. Компанийн хувьд тогтвортой удирдлага чухал нөлөөтэй байдаг. Гэвч 2025 онд 4 гүйцэтгэх удирдлага сольсон тул 2026 онд тогтвортой удирдлагаар хангах тал дээр ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ?

ТУЗ-ийн дарга Д.Тогтохбаяр: Үйл ажиллагааг тасалдуулахгүй байх үүднээс өмнөх захирлын хүлээлгэн өгсөн ажлыг дараагийн захиралд шилжүүлэх байдлаар олон удирдлага солигдсон нь үнэн. Уул уурхайн биржийн тухай хуульд заасан ТУЗ-ийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр ТУЗ томилогдсон цагаасаа хойш 2 удаа сонгон шалгаруулалт зарласан боловч шүүхийн маргаан болон Сангийн яамны чиглэлээс хамаарч хэрэгжүүлж чадаагүй. Одоогийн ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаа дуусаж байгаа тул дараагийн ТУЗ-д гүйцэтгэх захирал болон газрын захирлуудын сонгон шалгаруулалтыг хийж, бүтцийг шинэчлэх ажлуудыг хийх бүрэн боломж байгаа.

4. Эдийн засгийн өсөлт, инфляцтай уялдуулан компанийн ажилчдын цалин нэмэх тал дээр ТУЗ ямар бодлого хэрэгжүүлэх вэ?,

ТУЗ-ийн дарга Д.Тогтохбаяр: 2026 оны Бизнес төлөвлөгөөнд цалингийн зардлыг нэмэгдүүлэн баталсан. Компанийн хэмжээнд үйл ажиллагааны гүйцэтгэлээс хамаарч үе шаттай нэмэгдүүлэх эрхийг гүйцэтгэх удирдлагад олгосон байгаа.

Хувьцаа эзэмшигч Наранбилэг:

5. Монголын хөрөнгийн бирж нь аудитын компанийг сонгохдоо ямар зарчмаар сонгосон бэ? Яагаад заавал Үндэсний аудитын газар болон Грант торнтон ХХК -р аудит ажил хийлгэсэн бэ? Нэмэлт хувьцаа гаргахад үндэсний аудитын тайлан хүлээн зөвшөөрөгдөхгүй. Тэгэхээр яагаад ЕҮ эсвэл PWC гэх олон улсын аудитын компаниар хийлгэхгүй байгаа вэ? Санхүүгийн тайлан стандарт бус ажиглагдаж хэд хэдэн тохиолдлууд ажиглагдаж байна.

Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбат: Монголын хөрөнгийн биржийн 66% нь төрийн эзэмшил байдаг. Тийм учраас Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд хамаарагддаг тул Үндэсний аудитын газраас хөндлөнгийн аудитыг хийдэг зохицуулалттай байгаа. Үндэсний аудитын тайлангийн стандарт нь олон улсын стандартаас зөрүүтэй байдаг тул анхнаасаа ажлын даалгавар боловсруулахдаа тайланг англи, монгол хэл дээр тайлагнахаар зохицуулсан. Үүний дагуу Үндэсний аудитын газрын захиалгын дагуу Грант торнтон ХХК гэх гүйцэтгэгч компани сүүлийн 2 жил сонгогдож ажилласан байгаа.

6. Аудитын тайланд дотоод хяналтын орчин сул гэсэн дүгнэлт гарсан байна. Үүнийг сайжруулахтай холбоотой ямар арга хэмжээ авч хэрэгжүүлэх вэ?

Тайланд тусгагдсан зөвлөмжийн дагуу дотоод хяналт болон ТУЗ -ийн дэргэдэх дотоод аудит нь төлөвлөгөө гарган ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигч Анхзаяа:

7. Компанийн орлогын 60% орчмыг хүүгийн орлого бүрдүүлж байна. Энэ нь цаашаа хэр тогтвортой байх вэ?

Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбат: Нийт орлогын дийлэнх хувийг хүүгийн орлого бүрдүүлж байгаа. Энэ нь Уул уурхайн арилжааны гэрээний үнийн дүнгийн 10% -г дэнчин байршуулдаг. Үүнийг бид арилжааны банкны харилцах дансны хамгийн өндөр хүү болох 3%-р байршуулдаг. Цаашдаа Уул уурхайн биржийн арилжааны тухай хуульд өөрчлөлт орохгүй бол ямар нэгэн материаллаг өөрчлөлт гарахгүй гэдэг хүлээлттэй байна.

**САНАЛ ХУРААЛТ**

**Санал хураалт:** Санал хураалт 11 цаг 30 минутаас 11 цаг 45 минут хүртэл 15 минутын хугацаанд үргэлжлэв.

**Тооллогын комиссын тогтоолоор:**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хүчинтэй саналын хуудас өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.980 хувь зөвшөөрсөн, 0.002 хувь татгалзсан, 0 хувь түдгэлзсэн.
2. Компанийн 2026 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах тухай асуудалд хүчинтэй саналын хуудас өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.997 хувь зөвшөөрсөн, 0.002 хувь татгалзсан, 0.001 хувь түдгэлзсэн.

**ШИЙДВЭР:**

Хурлаас гарсан шийдвэрүүдийг Хурлын дарга Б.Хулан танилцуулав.

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлав.
2. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2026 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин батлав.

**Хувьцаа эзэмшигчдийн хурлын дарга Б.Хулан :** “Монголын Хөрөнгийн бирж” хувьцаат компанийн 2026 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагааг хааж үг хэлэв.

**Хурлын тэмдэглэлтэй танилцсан:**

Хурлын дарга



Б.Хулан



## **“МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ” ХК-ИЙН 2026 ОНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОВЧ ТЭМДЭГЛЭЛ**

**Хувьцаа эзэмшигчийн хурал болсон огноо, газар:** 2026 оны 04 дүгээр сарын 28 -ний өдөр “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн ээлжит хувьцаа эзэмшигчдийн хурал “Монголын хөрөнгийн бирж” ХК -ийн төв байрны 1 давхарт танхим болон цахим хосолсон хэлбэрээр 10 цаг 10 минутаас 11 цаг 50 минутын хооронд 1 цаг 40 минутын турш болж өндөрлөлөө.

**Хурлын ирц:** Хуралд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн нийт 242,549,108 ширхэг хувьцаа эзэмшиж буй 93 хувьцаа эзэмшигчид хуралд оролцож хурлын ирц 69.18% хүрч баталгаажсан.

### **Хуралд оролцсон төлөөллүүд:**

Монгол Улсын Сангийн яам:

Сангийн дэд сайд / Хурлын дарга – Б.Хулан

“Монголын хөрөнгийн бирж” ХК -ийн Төлөөлөн удирдах зөвлөл:

ТУЗ-ийн дарга - Д.Тогтохбаяр  
Ердийн гишүүн - Ж.Цогтбаяр  
Ердийн гишүүн - Ж.Бямбасүрэн  
Ердийн гишүүн – Т.Ганбаатар  
Хараат бус гишүүн - М.Банзрагч  
Хараат бус гишүүн - Н.Улаанхүү  
Хараат бус гишүүн - Г.Отгончимэг  
Хараат бус гишүүн – Р.Мөнхтөр

“Монголын хөрөнгийн бирж” ХК -ийн Хяналтын зөвлөл:

Хяналтын зөвлөлийн гишүүн – С.Хулан

“Монголын хөрөнгийн бирж” ХК:

Захиргаа, санхүүгийн газрын захирал - Х.Эрдэнэбүрэн  
Хяналт, шинжилгээний газрын захирал - А.Мөнхбаясгалан  
Үйл ажиллагааны газрын захирал - И.Жавхлан  
Бизнес хөгжлийн газрын захирал – Т.Хаш-эрдэнэ

### **Хувьцаа эзэмшигчийн ээлжит хурал нь дараах хөтөлбөрийн дагуу явагдлаа.**

Тооллогын комиссын дарга Б.Онон хурлын ирцийг танилцуулав. Хуралд нийт 242,549,108 ширхэг хувьцаа эзэмшиж буй 93 хувьцаа эзэмшигчид хуралд оролцож хурлын ирц 69.18% хүрснээр хурлыг эхлүүлэв.

1. Хурлын дарга Б.Хулан хурлыг нээж, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулав.
2. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбат танилцуулав.
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны ажлын тайланг ТУЗ-ийн дарга Д.Тогтохбаяр танилцуулав.
4. Компанийн 2026 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг Гүйцэтгэх захирлын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Мөнхбат танилцуулав.

5. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний сонгон шалгаруулалтыг зарлах, ТУЗ-ийн гишүүнд нэр дэвшигчдийг эцэслэн шийдвэрлэхдээ Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 21.2.2-д заасны дагуу ТУЗ-ийн гишүүний сонгон шалгаруулалтад төрийн төлөөлөл хэрэгжүүлэгчийг нэр дэвшүүлэх боломжоор хангаагүй буюу мөн хуулийн 21.2.1-т заасны дагуу уг асуудлаар хувьцаа эзэмшигчийн эрхийг хэрэгжүүлэгчээс санал, удирдамж авах нь зүйтэй тул Төлөөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгож томилох асуудлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн дараагийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэхээр хойшлуулав.
6. Нийт 5 хувьцаа эзэмшигч танилцуулгатай холбоотой асуулт асууж хариултыг холбогдох албан тушаалтнуудаас авав.
7. Хурлаар хэлэлцэх асуудал тус бүрээр хэрхэн санал өгөх талаарх видео зааврыг танилцуулах Тооллогын комиссын дарга Б.Онон танилцуулав.
8. Санал хураалт 11 цаг 30 минутаас 11 цаг 45 минут хүртэл 15 минутын хугацаанд үргэлжлэв.
9. Санал хураалтын дүнг тооллогын комиссын дарга Б.Онон танилцуулав.
10. Хурлын дарга Б.Хулан хурлыг хааж үг хэлэв.

**Хөтөлбөрийн хүрээнд “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн ээлжит хурлаар хэлэлцэн баталсан асуудлууд:**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах;
2. Компанийн 2026 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж батлах;

**Тооллогын комиссын тогтоолоор:**

1. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлтийг хэлэлцэж батлах тухай асуудалд хүчинтэй саналын хуудас өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.980 хувь зөвшөөрсөн, 0.002 хувь татгалзсан, 0 хувь түдгэлзсэн.
2. Компанийн 2026 оны Эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний саналыг хэлэлцэж, батлах тухай асуудалд хүчинтэй саналын хуудас өгсөн нийт хувьцаа эзэмшигчдийн 99.997 хувь зөвшөөрсөн, 0.002 хувь татгалзсан, 0.001 хувь түдгэлзсэн.

**Хурлын шийдвэр:**

Хурлаас гарсан шийдвэрүүдийг Хурлын дарга Б.Хулан танилцуулав.

1. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлав.
2. “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийн 2026 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин батлав.

**Хурлын тэмдэглэлтэй танилцсан:**

Хурлын дарга

Б.Хулан

2  
3  
4  
5